# ГАЛТ ТЭРЭГНИЙ ХӨДӨЛГӨӨН ЗОХИЦУУЛАЛТЫН НЭГДСЭН ТӨВ



E-NEWSLETTER

facebook.com/Rtcc.m0n
http://rtcc.mrtd.gov.mn
info@rtcc.mrtd.gov.mn
+976 77244409

# ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТОВЧ ТАЙЛАН

## 2024 оны 01 дүгээр сарын дугаар

## “ИНЖЕНЕР-ИРЭЭДҮЙ“ хөтөлбөрийн хүрээнд:

Салбарын мэргэжилтэн, инженерүүдийн мэдлэг ур чадвар, суралцах арга барил чиг хандлагыг нэмэгдүүлж, хос мэргэжилтэй болгох зорилгоор “ГТХЗНТ“ УТҮГ нь ОХУ-ын ИрГУПС-тэй санамж бичиг байгуулан төмөр замын салбарын инженерүүдийг “Мэдээллийн систем ба технологи“ мэргэжлээр 2.5 жилийн магистрын эчнээ хөтөлбөрт хамруулан 4-5 жил амжилттай хамтран ажиллаж байна. Хөтөлбөр амжилттай хэрэгжин өргөжин тэлж, нийт 5 мэргэжлээр элсэлт авж байна. Магистрын эчнээ ангийн 2-дугаар курсийн оюутнуудыг 2024.01.11-19-ний хооронд бүрэн хичээлд бүрэн хамруулан, багц кредит цагийг дуусгалаа.












## Төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудаас:

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн чиглэлээр 2024 онд хийх ажлын төлөвлөгөө боловсруулсан.

“ГТХЗНТ” УТҮГ-ын захирлын 2023.06.09-ний өдрийн А/31 дүгээр тушаалаар баталсан хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөр (2023-2027 он)-ийг 2024 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг захирлын тушаалаар батлуулсан.

Зам, тээврийн хөгжлийн сайдын 2023.12.27-ны өдрийн 26, 2024.01.08-ны өдрийн 01, 2024.01.22-ны өдрийн 02 дугаар шуурхай хуралдааны үүрэг даалгавар Зам, тээврийн хөгжлийн яамны Төрийн захиргааны удирдлагын газраас цахимаар ирснийг төвийн RTCC viber группт 2024.01.03, 2024.01.10, 2024.01.24-ний өдөр байршуулж нийт ажилтанд шуурхай мэдээлсэн. Сайдын шуурхай хуралдаанаас өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг захиралд танилцуулж ТЗУГ-т цахимаар тайлагнасан.

ЗТХЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын баталсан хуваарийн дагуу 2024.01.18-ны өдөр төвийн 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг хэлэлцсэн. ЗТХЯ-ны Бодлого, төлөвлөлтийн газар, Төмөр зам, далайн тээврийн бодлого зохицуулалтын газар, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын саналыг гүйцэтгэлийн төлөвлөгөөнд бүрэн тусгаж ЗТХЯ-нд цахимаар 4, цаасан хэлбэрээр 2, нийт 6 удаа хүргүүлсэн. Гүйцэтгэлийн төлөвлөгөө 2024.01.25-ны өдөр батлагдсан. Төлөвлөгөөг RTCC viber группт 2024.01.25-ны өдөр байршуулж нийт ажилтанд танилцуулсан. Төлөвлөгөөг хэвлэж ХАБЭА-н самбарт 2024.01.26-ны өдөр байршуулав.

Тайланд сард явуулсан албан бичиг 63, ирсэн албан бичиг 41, тушаал 11, өргөдөл 2, нийт 117 баримт бичгийг албан хэрэг хөтлөлтийн хууль тогтоомж, стандартын дагуу хөтөлж бүрдүүлсэн. Цахимаар болон цаасаар ирсэн албан бичиг, өргөдлийн бүрдэлийг шалгаж бүртгэлийн дэвтэрээр бүртгэж бүртгэл-хяналтын карт, танилцуулах хуудсаар танилцуулж, компьютерт мэдээлэл оруулах төхөөрөмжөөр скайнердаж, удирдлагын цохолтоор холбогдох ажилтанд шилжүүлж системийн ирсэн бичигт нэмж, компьютерт PDF форматаар төрөлжүүлж хадгалан холбогдох ажилтнаар хүлээн авсан талаар бүртгэлийн дэвтэрт гарын үсэг зуруулсан. Явуулах албан бичиг, тушаалын төслийг цахимаар хүлээн авч, баримт бичгийн найруулга зүй, үг үсгийн алдаа, бүрдэлийг шалгаж удирдлагад танилцуулж, гарын үсэг, тэмдэгээр баталгаажуулж, бүртгэж, дугаар олгож, компьютерт мэдээлэл оруулах төхөөрөмжөөр скайнердаж, системийн явсан бичигт нэмж, компьютерт PDF болон doc файлаар төрөлжүүлж хадгалан эйбл систем болонхадгалан эйбл систем болон цахим шуудангаар харилцагч байгууллагад илгээв.

## "Төмөр замын тээврийн салбарын статистик мэдээний нэгдсэн санг бүрдүүлэн ажиллаж байна.

Төмөр замын байгууллагууд харилцан мэдээлэл солилцох журмыг хэрэгжүүлж төмөр замын салбарын мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх, хөтлөх, боловсруулах, ашиглах үйл ажиллагааг хариуцан ажиллаж байна. Төмөр замын тээврийн салбарын статистик мэдээллийн санд хоногийн 155 мэдээ, сарын 12 мэдээг бүрдүүлж мэдээллийн нэгдсэн санд байршиж байна. ЗТХ-ийн сайдын 2020 оны А/154 дүгээр тушаалын хавсралтаар баталсан "Төмөр замын байгууллагууд харилцан мэдээлэл солилцох журам", ЗТХ-ийн 2021 оны "Зам, тээврийн салбарын статистикийн мэдээлэл авах, мэдээллийн сан бий болгох заавар, маягт, нөхөх заавар, үзүүлэлт батлах тухай" А/93 дугаар тушаалын хүрээнд ЗТХЯ-нд сарын статистик мэдээг албан бичиг болон цахим шуудангаар хүргэж тайлагнасан. Суурь бүтэц эзэмшигчийн тээвэрлэсэн ачааны хэмжээ (импорт, экспорт, дамжин өнгөрсөн, орон нутаг-тонн), чингэлэг тээвэрлэлт (импорт, экспорт, орон нутаг, транзит-тонн), зорчигч тээвэрлэлт (олон улс, орон нутаг-хүн) 2023 оны 12 дүгээр сарын ачаа тээврийн статистик мэдээг нэгтгэн болосруулж 2023 оны 12 дугаар сарын 20-ний өдөр төвийн цахим хуудас, олон нийтийн сүлжээнд байршуулж мэдээлсэн.



## Галт тэрэгний хөдөлгөөний нэгдсэн зурмагийн гүйцэтгэлд дүн шинжилгээ хийх, тайлан мэдээг танилцуулах

Нэгдсэн зурмагийн 2023 оны 12 дугаар сарын тасалдалд дүн шинжилгээ хийж, ЗТХЯ СХГ-д 2024 оны 01 дүгээр сарын 11 өдрийн 15 дугаарын албан бичгээр хүргүүлсэн. 2023 оны4 дүгээр улирлын тасалдалд дүн шинжилгээ хийж, ЗТХЯ СХГ-д 2024.04.11 өдрийн 13 дугаарын албан бичгээр хүргүүлсэн. 2023 оны 04 дүгээр улиралын суурь бүтэц хоорондын галт тэрэгний солилцоонд дүн шинжилгээ хийж, тайлан болон албан даалгаварыг 2024 оны 01 дүгээр сарын 11-ний өдөр БТЕГ-16, МТЗ-17, ТТЗ-18, УБТЗ-19, МТЛайн-20 дугаарын албан бичгээр хүргүүлсэн. Суурь бүтэц хоорондын галт тэрэг солилцоо, хилийн галт тэрэг солилцоог нэгтгэн, экспортын ачааны нэр төрөлөөр мэдээ гарган, танилцуулсан.



## “Монгол улсын хилээр нэвтэрч буй хөдлөх бүрэлдэхүүнд шинээр дугаар олгох, баталгаажуулах, мэдээллийн санд бүртгэх, ЗТХЯ-ыг мэдээллээр хангах” ажлын хүрээнд:



"Халиун Уул" ХХК-д 2024.01.11-ний 11 дугаартай албан бичгээр хөдлөх бүрэлдэхүүн түрээслэгчийн Т36 кодыг шинээр олгож, түрээсийн 10 вагоныг мэдээллийн санд бүртгэсэн. "Аксис оф ворлд" ХХК-ийн ачааны 100 хагас вагонд 2024.01.26-ны 59 дугаартай албан бичгээр шинээр дугаар олгосон.

"Ла маккина плаза" ХХК-ийн 200, "Смарт деливери монголиа" ХХК-ийн 100, нийт ачааны 300 хагас вагонд урьдчилан олгосон дугаарыг тус тус 100% буцаан авч, дээрх хуулийн этгээдэд 2024.01.25-ны 50, 51 дугаартай бичгээр мэдэгдсэн.



**“Төмөр замын тээврийн аюулгүй байдалтай холбоотой зарим объект, үйл ажиллагаанд гэрчилгээ олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох, нөхөн олгох, санал дүгнэлт гаргах, гэрчилгээжүүлэлтийн мэдээллийн сан үүсгэх, хөтлөх ажлыг хэрэгжүүлж байна**

Зам тээврийн салбарын нэгдсэн платформд гэрчилгээ сунгуулсан, өөрлөлт оруулсан, шинээр гэрчилгээ авсан нийт 37 замын мэдээлэл оруулсан. Төмөр замын тээврийн аюулгүй байдалтай холбоотой зарим объект, үйл ажилгаанд гэрчилгээ олгох, сунгах түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох, нөхөн олгох 73 баримт бичгийн бүрдлийг нягтлан шалгаж үүнээс 20 компанийн материал бүрдэл дутуугаас буцаасан, 31 компанийн санал дүгнэлт гаргах, шийдвэрлүүлэхээр уламжилж, гэрчилгээжүүлтийн мэдээллийн сан үүсгэн, хөтлөх ажлыг хэрэгжүүлсэн. Гэрчилгээжүүлэлтийн сарын статистик мэдээг бэлтгэн боловсруулаж, ажлын хэсгийн чиг үүргийн дагуу “Тусгай зөвшөөрөл, гэрчилгээжүүлэлтийн цахим систем”-д ажиллаж, ажлын хэсгийн хуралдааныг 2024 оны 1 дүгээр сарын 22-25 ны хооронд зохион байгуулж хурлын тэмдэглэллийг ЗТХЯ-ны ТЗДТБЗГ-ын мэргэжилтэн хүргүүлсэн. Гэрчилгээжүүлэлтийн ажлын хүрээнд Амгалан өртөөн дэх зэвсэгт хүчний 310-р ангийн замынг газар дээр нь үзэж ажлын хэсэгт байдлыг танилцуулж ажилласан.



## ХҮНИЙ НӨӨЦИЙН ХӨГЖЛИЙН ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД:

"ГТХЗНТ" УТҮГ нь 2024 онд хэрэгжүүлэх Хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөрийн төлөвлөгөөг баталсан. Хүний нөөцийг хөгжүүлэх, мэргэжил, чадварыг тасралтгүй дээшлүүлэх олон талт арга хэмжээнд хамруулах зорилгоор дараах сургалтыг зохион байгуулан, төвийн удирдлага, ажилтан албан хаагчдыг хамруулллаа. 2024.01.16-нд өдөр Сэтгэл зүйч Дамдинсүрэнгийн Түмэн-Өлзийтэй хамтран "Ажлын байрны стресс, депресс, түүнээс хэрхэн сэргийлэх" 2024.01.17-нд өдөр Нийслэлийн иргэдийн хэрэглээний боловсролын төвтэй хамтран “Хамт олны эерэг харилцаа, сэтгэл зүйн эрүүл мэнд, Эрүүл, амьдралын зөв дадал зуршил, Зөв зохистой хооллолт, ундны усны стандарт" Цаашид төвийн ажилтан албан хаагчдыг хөтөлбөрийн төлөвлөгөөнд тусгагдсан олон сургалтад хамруулахаар төлөвлөн ажиллаж байна.








**Газар бизнес төвийн байр,**
**Тээвэрчдийн гудамж,**
**2-р хороолол, 1-р хороо,**
**Баянгол дүүрэг, 16052,**
**Улаанбаатар хот, Монгол улс**